

# ӨӨЛДИЙН ХҮРЭЭ, ӨӨЛД БЭЙСИЙН ХҮРЭЭ, ШАР СҮМД ШАВИЛАН СУУЖ БАЙСАН ӨВГӨН ЛАМ НАРААС АВСАН ЯРИА

---

*Майер Жужа*  
(доктор (PhD), дэд профессор, “Номын үүд” Бурхны шашны дээд сургууль  
(A Tan Karija Buddhista Fõiskola), Унгар улс, Будапешт хот)

*Телеки Кристина*  
(доктор (PhD), Өэтвөш Лорандын нэрэмжит Их Сургууль  
(Eötvös Loránd Tudományegyetem),  
Монгол ба Төв Ази судлалын тэнхим, Монгол судлалын төв,  
Унгар улс, Будапешт хот)

---

## УДИРТГАЛ

Энэхүү өгүүлэлд<sup>105</sup> хэлмэгдүүлэлтийн өмнө тус хийдүүдэд шавилан сууж байсан зарим өндөр настан лам нараас Өөлдийн хүрээ хийдүүдийн талаар авсан ярилцлагуудын агуулгыг танилцуулах болно.

Тус ярилцлагуудыг бид 2006 оноос 2009 он хүртэл 40 монгол ламын 40 орчим хуучин хийдийн тухай ярьсан 80 яриа авсан байна. Зарим лам нартай 2-3 удаа уулзах боломж гарсан, тэд нараас хоёр, гурван удаа илүү дэлгэрэнгүй асууж, нэгээс илүү ярилцлага авсан. Ихэнхийг нь Улаанбаатар хотод авсан. 1989-1990 онд ардчилсан өөрчлөлт гарч бурханы ном дахин сэргэхийн үйл ажиллагаанд өргөнөөр оролцсон, хуучин хүрээ хийдэд шавилан сууж байсан, Монголын Бурханы шашны түүхийн талаар сайн мэдэх, өөрийнхөө нүдээр түүх үзсэн өвгөн лам нартай хийсэн ярилцлагууд хэвлэгдсэн материал тэр үед бараг олдохгүй, их ховорхон байсан. Тэр үед тус лам нар нас маш өндөр, эд нараас ярилцлага авах боломжтой хугацаа богинохон учраас бид өөрсдөө чадлаараа, боломжоороо ярилцлага авахаар шийдсэн.

Анхны ярилцлагуудыг дуу хураагуураар хураасан (ламын зургийг нь бас авч), дараа жилүүдэд заримыг нь дүрс бичлэгтэй хийсэн. Тэр үед энэ настангууд Гандантэгчэнлин хийд, Зүүн хүрээ Дашчойлин хийд, Ламрим дацан, Манба дацан, Дамбадаржайлин хийд, Төв аймгийн Зуунмодын Дашчойнхорлин

---

<sup>105</sup> Илтгэлийн анхны хэсгийг Майер Жужа, хоёр дахь хэсгийг Телеки Кристина бичсэн.

хийд гэх мэтийн хийдүүдэд хурдаг байсан, зарим нь их өндөр нас хүрсэн учраас зөвхөн дүйцэн өдрүүдээр хийддээ ирдэг. Энэ лам нар шашин ном дахин сэргэх үед эргэж лам болж хуучин уламжлалаа сэргээхэд идэвхийлэн оролцож маш их үүрэг гүйцэтгэсэн. Бид нартай уулзах үед бүгдээрээ 80-аас дээш настай байсан, зарим нь зуун нас ч гарсан байв. Эд нарын хорьдугаар зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн талаарх аман мэдээ нь монголын бурханы шашны түүхэн уламжлалыг гэрчлэх үнэтэй бодит сурвалжууд болно.

### Судалгааны арга зүйн талаар

Бид анхны ярилцлагуудаа 2006 онд авсан. Чухам юу, юу асуухаа бодож асуух асуултын маягт бэлдэж шууд энэ асуултуудыг, асуултуудын хуудасны дагуу ярилцлага авч эхэлж судалгаагаа явуулсан билээ. Олон ярилцлага авсны дараа асуултын хуудсандаа шинэ асуултуудыг нэмж ярилцлагууд авах арга зүй яваандаа боловсруулсан. Энэ маягтуудыг дараа зөвхөн бид өөрсдөө хэрэглэсэн ч биш, 2007 онд “Монголын сүм хийдийн түүхэн товчоо” хэмээх төсөл (Documentation of Mongolian Monasteries project)<sup>106</sup> гарч бид нарын боловсруулсан асуултуудын маягыг Монгол орон даяар ашиглаж хуучин хүрээ хийдүүдийн тухай аман түүх цуглуулсан нь бидний эхлүүлсэн судалгааны бас нэгэн үр дүн байсан юм.

Энэ асуултуудыг хариулсан лам нар бидэнд эхлээд өөрийнхөө талаар танилцуулсан: хэдэн онд, хаана, хэзээ төрсөн, хэдэн насандаа хэдэн онд хаана, аль хүрээ хийдэд лам болж шавилан суусан, түүний аль дуганд юм уу, аль дацанд хурсан, ямар, ямар цол хэргэм, мяндаг тушаал хаасан, хэлмэгдүүлэлтийн үеээс хойших хувь заяа, 1990 оноос хойш хэзээ, хаана дахин лам болсон гэх мэт. Түүний дараа шавилан суусан хийдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Жишээлбэл, хийдийн нэр, хуучин болон орчин үеийн засаг захиргааны дагуу байршил, хийдэд ойрхон газар, уул, тахиж байсан уул овоо, гол усны нэр гэх мэт. Үүнээс гадна хийдийн дацан, сүм дугануудын тоо, тус тусын нэр хэлж өгч, суварга, хүрд хаана байрлуулсныг хэлээд, лам нарын зарим нь хийдийнхээ бүдүүвч зургийг зурахад ч тусалсан. Хуучин хийдийнхээ лам нарын талаар бол лам нарын тоо, хийдийн тэргүүн юм уу, толгойлох хамба лам, бусад мяндаг тушаалтнууд, хутагт хувилгаан, нэр алдартай лам нар, тэр хавьд хурж байсан нэртэй зоч лам нар гэх мэтийн талаар ярьж өгсөн. Үүнээс ч чухал нь хийдийн үйл ажиллагаа, зан үйлийн дэлгэрэнгүй мэдээлэл, жишээ нь хийдийн гол шүтээн, сахиус, ядам, Чойр дацангийн игчаа, жилийн дүйцэн хурлууд ба зан үйлийн, уншлагын онцлог байдлын тухай мэдээлэл байв. Үүнээс гадна лам нар нь хүрээ хийдүүдийн ойрхон амьдардаг байсан энгийн хүмүүс болон борчуул, хятад наймаачдын тухай ч дурсамжаа хэлж өгсөн. Иймээс энэхүү ярилцлагууд зөвхөн монголын бурханы шашны түүхийн үүднээс ч биш, монголын түүхийн үүднээс авч үзвэл ч чухал үнэтэй бодит сурвалжууд байна.

<sup>106</sup> Тус төслийн үр дүнг [www.mongoliantemple.org](http://www.mongoliantemple.org) цахим хуудснаас үзнэ үү. Тус төслийн дагуу бид ч гэсэн хэдхэн өгүүлэл гаргасан байна: Majer-Teleki 2008, Majer-Teleki 2010, Majer-Teleki 2006, Majer-Teleki 2007, Teleki 2009.

Энэ 80 ярилцлагыг сүүлдээ ихэнхдээ Телеки Кристина Монголын ШУА-ын Түүхийн Хүрээлэнгийн тусламжтайгаар бичиг үсэгт буулгасан, “Өндөр настан лам нарын яриа” гэсэн нэрээр хэвлэхэд бэлдээд байна. Хоёр дахь ботид бол Телеки Кристинагийн 2007-2017 онд 34 ламаас авсан 47 ярилцлага орсон байна (Майер Жужагийн хувьд олон жил Монголд очиж судалгаа үргэлжлүүлэх боломжгүй өнгөрсөн учраас харамсалтай энэ ажил 2009 онд бүр тасарсан).<sup>107</sup> Энэ хоёр боть одоогийн байдлаар харин хэвлэхэд бэлэн болсон мөртлөө гараагүй, хэвлэгдээгүй байна. 2023 онд хэвлэгдэх гэж байна:

- Майер Жужа-Телеки Кристина, *Өндөр настан лам нарын яриа. XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн талаар авсан ярианууд II (2005-2009)*. Улаанбаатар 2023 (хэвлэлд орсон)
- Телеки Кристина, *Өндөр настан лам нарын яриа. XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн талаар авсан ярианууд II (2007-2017)*. Улаанбаатар 2023 (хэвлэлд орсон)

Телеки Кристинагийн авсан ярилцлагууд харин англи хэлэнд орчуулаад англи хэлээр Унгар улсын Будапешт хотод хэвлэгдсэн байна.<sup>108</sup> Дээр нь зарим ярилцлагын дагуу зарим хуучин хүрээ хийдүүдийн талаар англи болон унгар хэлээр өгүүлэлүүд бас хэвлүүлсэн байна.<sup>109</sup>

**Ярилцлагуудын дуу хураагуураар хураасан дуу ба дүрс бичлэг нь одоогийн байдлаар хоёр зохиогч Майер Жужа, Телеки Кристинад хадгалагдаж байна. Мөн ШУА-ийн Түүхийн хүрээлэнд зарим нь хадгалагдаж байна. Энэхүү дуу, дүрс бичлэг бүгдийг цаашид нь хадгалагдах ба сонирхогчдод сонсож үзэж ашиглах боломжтой болгохын тулд онлайнаар тавих юм уу, ямар нэгэн архивт байрлуулах төлөвлөгөө бас бий. Илтгэл тавих үед сонсогчдод тус ярилцлагуудаас зарим хэсгийг ч үзүүлсэн байна.**

### **Өөлдийн хүрээ хийдүүдийн талаарх ярилцлагууд**

Энэ олон ярилцлагуудаас Өөлдийн хүрээ хийдүүдийн талаар гурван лам мэдээлэл, аман түүх ярьж өгсөн байна:

- Лочингийн **Ишжамц** (Гандантэгчэнлин хийдийн Дашчойнпэл дацан)
  - Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын **Өөлдийн хүрээ Ганданпунцоглин хийдийн** талаар
- Цэгмидийн **Лувсан** (Гандантэгчэнлин хийд)
  - **Ховдын Шар сүмийн** талаар (дараа нь Богдын хүрээний Шүтээний аймагт сууж байсан)
- Шижирийн **Түгж** (Ламрим дацан)
  - Архангай аймгийн Өлзийт сумын **Өөлд бэйсийн хүрээний** талаар

<sup>107</sup> Энэ өгүүлэлд Телеки Кристинагийн ганцаараа тэмдэглэж авсан ярианууд ороогүй.

<sup>108</sup> Teleki 2022.

<sup>109</sup> Majer 2012, Majer 2013, Majer-Teleki 2013, Majer-Teleki 2016, Teleki 2012, Teleki 2015, Teleki 2017.

Энэхүү өгүүлэлд энэ гурван ярилцлагын агуулга, энэхүү хийдүүдийн талаарх мэдээллүүдийг багтсан байна. Эхлээд Ишжамц ламаас авсан ярилцлагаас Өөлдийн хүрээний талаарх материалыг танилцуулна.

**Лочингийн Ишжамц (1915-2015) Өөлдийн хүрээ Ганданпунцоглин хийдийн талаар:**

Ишжамц гуай 5 наснаасаа 23 нас хүртлээ Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Өөлдийн хүрээ Ганданпунцоглин хийдэд шавилан суусан. 1960-аад онд хотод ирээд Гандантэгчэнлин хийдэд дахин лам болоод Дашчойнпэл дацангийн унзад болсон. Ишжамц ламаас бид гурван ярилцлага авсан (2006, 2009 онд, дараа нь 2010 онд Телеки Кристина), нэг нь дүрс бичлэгтэй. Ишжамц ламын өөр нэг яриаг [www.mongoliantemples.org](http://www.mongoliantemples.org) цахим хуудаснаас үзэж болно.



*Зураг 1. Л.Ишжамц (МБШ төв -Гандантэгчэнлин хийдийн Дашчойнпэл дацангийн Дархан умзад)*

Л.Ишжамц гуайн хэлж өгсөнөөр Өөлдийн хүрээ Ганданпунцоглин 500 гаруй ламтай хийд байсан. Хийд нь том хашаатай, хэрэмтэй, дуганы хэрэм тойруулаад суваргуудтай байсан. Нийт 21 суварга байсан. Тус хийд хуучин засаг захиргааны дагуу Өөлдийн хошуунд байдаг байв. Өөлдийн хошуу нь 11 овоотой байсан: Цамбагарав, Мараагийн овоо, Хайрхан, Шургийн овоо, Бураа, Салхит, Хайрхан, Харгант, Шинэ-Овоо, Аваанбэлчир, Нүцгэн.

Хийдийн нэртэй лам нараас зарим нь: хамгийн нэр алдартай бол Дамбийдонмэ (1887-1937) гэдэг хувилгаан лам байсан, түүнээс гадна Аршидын хувилгаан лам нь хамба тушаал хааж байсан. Бусад лам нараас хамгийн том лам нь Чүрүм гавж, агримба, гэгээн байсан. Найдан бүрэлгүү гэдэг хувилгаан лам, Нэй-үцэн (!) лам бас хийд дээр амьдарч байсан. Хийдийн эргэн тойрон цөөхөн зоч хурж, Лүйжин тавьдаг байсан.

Хийдийн дуган дацангуудын тоо, нэрийн талаар бол энэ зургаан дугантай хийдэд Чойр дацан, Цогчин дацан, Жүд дацан, Дүйнхор дацан, Авгын дацан (Ганданпунцоглин, Дашгэмпил дацан, Чойраа дацан) байсан. Дуганууд тус тусдаа хэрэмтэй байсан. Өөлдийн хүрээ Ганданпунцоглин дөрвөн жастай байсан, жасууд нь Цогчин жас, Чойр жас, Дүйнхор жас, Жүд жас гэж нэртэй байв. Чойр дацан бол Гүнчин игчаатай байсан, тэнд гавж, аграмбын дамжаа барьдаг байсан. Хийд

дээрээ Шунхан Ганжуур, Алтан Ганжуур гээд ном судрууд бүтнээр хадгалагдаж байсан. Өөлдийн хүрээ Ямандаг, Гончойлхасүм, Намсрай ийм таван сахиустай, бас Дамжин сахиустай байсан.

Цагийн хурлуудын хувьд Хангал, Цогчин, Жүд, Дүйнхор, Гүнрэг, Чойр, Бурхан багшийн дүйцэн өдрүүд, Богд ламын дайчод хурдаг байсан. Цам нь жилд хоёр удаа өвөл, зун гардаг байсан. Хаврын эхэн сарын 15-нд хийдийн лам нар Майдар эргэдэг байсан. Хаврын сүүл сард Чойрын их хуралтай байв. Хайлан бас хурдаг байсан.

### **Цэгмидийн Лувсан (1914-2012) Ховдын Шар сүмийн талаар<sup>110</sup>**

Лувсан лам 1914 онд төрсөн. 8 наснаасаа 1931 он хүртэл Ховд аймгийн Ховд хотын Шар сүмд шавилан суусан. 1931 онд Улаанбаатар хотод ирж Богдын хүрээний Шүтээний аймагт сууж, 1937, 1938 он хүртэл лам байсан. 1989 онд Гандантэгчэнлин хийдэд эргэж лам болсон. Лувсан ламаас бид дуу хураагуураар хоёр ярилцлага авсан (2006, 2009 он), нэг нь дүрс бичлэгтэй (2009). Мөн Телеки Кристина бол 2010 онд Шар сүмийн туурийг тэмдэглээд дахин нэг ярилцлага авсан. Лувсан ламын өөр яриаг [www.mongoliantemples.org](http://www.mongoliantemples.org), [www.amantuuh.socanth.cam.ac.uk](http://www.amantuuh.socanth.cam.ac.uk) цахим хуудаснаас үзэж болно.



*Зураг 2. Ц.Лувсан (МБШ төв -Гандантэгчэнлин хийдийн Дашчойнпэл дацангийн лам, гавж)*

Ц.Лувсан ламын хэлснээр Ховдын Шар сүм нь Буянт голын хойд эрэгт оршиж байсан. Манжийн эзэн хааны байгуулсан 8 дугантай, 200-аад ламтай, хэрмэн хашаатай сүм байсан. Гол онцлог нь 1921 он хүртэл гурван хувилгаан ээлжээр тэргүүлдэг байсан (Жалханз, Дилов, Нарованчин хутагт нар). 1938 онд Шар сүмийн байгуулсан 177 ой болсон. 8 шар сүм нь Цогчин дуган, Агва, Дэмчиг, Чойр (1918 онд байгуулсан, Гүнчин игчаатай), Алтайн савдаг, Хангайн савдаг, Жалчинши. Баруун сахиус, Зүүн сахиус гэж хоёр дуган байсан, баруун сахиус нь Ригсүмгомбо, зүүн нь Гончойлхасүм. Энэ найман шар өнгөтэй сүмийг хятадын хөх туйпуугаар барьсан. Цогчин дуган нь нэг давхартай. Манжийн эзэн хааны сүүлд барьсан дуган нь хоёр давхар байсан. Сүм нь их олон бурхантай байсан. Хийдийн урд нэг том,

<sup>110</sup> Телели Кристинагийн бичсэн хэсэг нь эндээс эхэлж байна. Лувсан гуай, Түгж гуайн ярианууд миний одоогийн “Хангай нурууны тайлга тахилга” хэмээх судалгаанд ч хувь нэмэр оруулна (Унгар улсын Үндэсний судалгаа, хөгжил, инновацийн газар, NKFIH OTKA FK\_21).

хоёр гурван жижиг суваргатай. Жас нь ганцхан том Цогчин жас гэж байсан.

Хурлын хувьд бол зуны эхэн сарын шинийн 8-нд мянган тахил өргөж, Маналын Их манал хурдаг байсан. Цам нь хаврын эхэн сарын 14, 15-нд гардаг байсан. 14-нд бас сор зална. Майдар эргэх нь хаврын эхэн сарын 15-нд байсан. Цамын хувцас хэрэглэлийг Манжийн хаанаас өгдөг байсан. Гардаг цамууд л хоёр чамбон, 21 Дарь эх, Арван хангал. Дөчин хэдэн баг гардаг байсан. Өвлийн сүүл сарын 29-нд, хаврын эхэн сарын 14-нд цамтай. Шар сүм нь Ганжуур, Данжууртай байсан. Шунхан Ганжууртай. Зундаа Ганжуураа тэвэрч аваад барьж байгаа дуганаа эргэдэг байсан. Хийдийн эргэн тойрон жилд нэг удаа Ганжуур эргэнэ. Дөрвөн талд нь үдлээд. Хайланг 40-50, 60, 100 лам нар Цогчин дуганд хурдаг байсан. Цагаан сарын шинийн хоёронд тахидаг Шар сүмийн овоо гэж ганц овоо байсан. Шар сүмийн хойд талын толгой дээр. Мөн нилээд холхон бол Жалханз ламын овоо байсан юм.

Лам нар Шар сүмийн хэрмийн хашааны гадуур, гэр хашаатай байдаг байсан. Хийдэд том хүрд байгаагүй. Жижиг хүрднүүд байсан. Бүрэлгүү гэгээн гэж зоч лам байсан. Мөн тэр хавьд Чогсүм гэдэг ганц л лам лүйжин тавьдаг байсан. Хандмаа нар огт байгаагүй. Шар сүм нь хамбагүй, харин тэргүүн лам, дэд ламтай байсан. 1921 оны үед тэргүүн нь Жалханз хутагт байсан. Дараа нь Данзан тэргүүнтэй болсон. Хамгийн том лам нар нь Дамбийдонмэ, Данзан, Гомбосүрэн гээд лам байсан. 1937-39 онд 60 гаруй лам нар баригдсан. Дуган цөмийг нь буулгаад нураасан байна. Ойрхон хятадын сангийн хотод Гэсэр сүм, Дарь эхийн сүм хоёр байсан. Шар сүм дээрээс очиж, Гэсэр тахидаг байсан гэнэ лээ. Хятадууд уншуулдаг байсан. Тэнд баян пүүсүүд байсан. Гүрдэв гэгээн гэж Завханд байсан төвөд лам, Шар сүмд хааяа очдог байсан.

### **Шижирийн Түгж (1923-2014/15) Өөлд бэйсийн хүрээний талаар**

Түгж лам 10 наснаасаа Архангай аймгийн Өлзийт сумын Өөлд бэйсийн хүрээнд 4 жил шавилан суусан. Бид Түгж ламаас 2009 онд Ламрим дацанд дүрс бичлэгтэй ярилцлага авсан. Мөн Телеки Кристина 2010 онд түүнээс дуу хураагуураар ярилцлага авсан. Нэг нь дүрс бичлэгтэй. Тэр Өөлдийн түүхийн талаар үүнийг дурдсан:



*Зураг 3. Ч.Түгж (Өөлд бэйсийн хүрээний унаган шавь)*



“Өөлд гэдэг чинь Галдан бошигт Зүүн Монголд хятадууд байхад Галдан бошигт баруун Монголоос наашаа их цэрэгтэй ирээд хятадтай байлдаж, байлдаж тэгээд Орхоны тэнд очиж бас жаахан тааруухан байлдсан юм уу, тэгээд хэсэг хүмүүсээ үлдээд цаашаа явсан. Тэд нар өөлд хүн, Өөлд бэйс түүгээрээ нэрлэсэн. Монгол онцгой байдлыг хэлэхэд Халх эмэгтэйчүүд дэрвэгэр үстэй, манай Өөлдүүд үсээ уутанд хийгээд унжуулдаг. Өөлд бол өөр. Тэр нь тойрсон сумуудын бүх эмэгтэйчүүд дэрвэгэр үстэй, манайхан бол өөр. Өөлдүүд бол түүгээрээ ялгагдаж байсан. Дээр үед Галдан бошигт үлдсэн цэргүүдэд газар өгсөн. Урагшаа Хотонт, Өлзийт, Өгий нуур энэ гурван суманд Өөлд байдаг гэнэ лээ. Манайхыг бол өөлдүүд Өөлд бэйсийн хүрээ гэдэг юм.”

Түгж ламын цаашид ярианаас дүгнэхэд, Өөлд бэйсийн хүрээ нь Орхон голын хавьд, Хөшөөтийн дэнжийн тэнд, баруун талдаа модтой, уултай, 100 гаруй ламтай жижиг хүрээ байсан. Лам нарын сууц, хашаа нь Баруун хүрээ, зүүн хүрээ гээд хоёр гудамтай байсан. Өвөл лам нар гэрт суудаг байсан. Зун жижиг жижиг байшинтай. Хүрээний нэг онцлог нь төвөдийн гачин багштай, алтан Зуу шүтээнтэй хийд байсан. 2, 3 дуган өнөө хүртэл үлдсэн. Дуганууд дан дуганууд байсан. Үүнд: Цогчин дуган, Чойрын дацан, Жүдийн дацан, Маналын дацан, Дарь эхийн дацан, Манба. Зуугийн шүтээний нэг сүм байсан. Хүрээний 4 талд суварга байсан. Мөн Чойрын дуганы тэнд. Чойр нь дугуй хэлбэртэй модон дуган байсан. Цогчин дуганы тэнд том хүрд байсан. Хүрээ олон хүрдтэй. Гомбо сахиустай. Цам нь зуны дунд сарын 15-нд гарсан. Хоёр буга, Цагаан өвгөн, Шар өвгөн, Хөх өвгөн, Дамдин Чойжоо, шанагууд лав гардаг байсан. Зуны дунд сарын шинийн 15-нд Майдар эргэнэ. Хүрээний 4 талд мод байсан. Тэнд тойроод цам цамнаж Майдар эргэдэг байсан. Ногоон морьтой тэргэнд мөргөн барина. Ганжуур тэгэж эргэхгүй, хайлан хурахгүй. Зулын 25-нд хурал хурж байсан. Өвөл Догшидуудад зориулж долоо хоног өдөр шөнөгүй хурал хурдаг байсан. Цагаан сарын өмнө. Хүрээнд Загд чойжин буудаг байсан. Хар болоод 1938–1939 онд баригдсан байх. Лам нар зодын номоо хүрээний гадаа тавьдаг байсан. Зод тавих хүмсүүдийн дотор эмэгтэйчүүд явдаг байсан.

Хамба лам бол чинь Чойрын дуганы хамба лам болбол Төвөдөөс ирсэн Гачин лам байсан. Дэд хамба нь Чойсүрэн лам гэж байсан. Жүдийн хамба нь Содном лам гэж байсан. Чойрынхон Сандуйжав гэж байсан. Чойр нь домын дамжаа, гавжийн дамжаатай байх. Тэр хавьцанад бас бөө байсан. Гэтэл тэр шарын шашнаас өөр юм.

## Дүгнэлт

1920-1930-аад оны үед Өөлдүүд Ховд ба Архангай аймагт том хүрээ хийдүүдтэй байсан юм. Ховд аймгийн Өөлдийн хүрээ 500 гаруй ламтай, Манжийн эзэн хааны байгуулсан Шар сүм 200 ламтай, Архангай аймгийн, төвөд гачин ламтай Өөлд бэйсийн хүрээ 100 гаруй ламтай байсан. Бүгд нь өөр өөр, онцлогтой. Бүгдийг нураасан боловч бүгдийн уламжлал дахин сэргээгдсэн. Ярилцлага өгсөн лам нар бидэнд багын дурсамжуудаа ярьж өгсөн учраас зарим нь их нарийн, зарим нь жаахан

дутуу болсон. Тэд нараас хураан авсан аман түүх нь 1920-1930-аад үеийн Өөлдийн гурван хүрээ хийдийн байдлыг маш сайн харуулах үнэт ховор сурвалжууд юм. Ярилцлагууд нь бүрэн бүтнээр энэ онд номын хэлбэрээр гарах болов уу хэмээн бид найдаж байна.<sup>111</sup> Гурван эрдэмтэй ламын ярьж өгсөн аман мэдээг архивын баримт, орчин үеийн судалгааны ном бүтээлдүүд, бичсэн сурвалжуудтай харьцуулбал Өөлдийн гурван хийдийн олон зуун жилийн түүхийг судалж тодруулж болно.

## Ном Зүй

1. Majer, Zs., Delgeriin Choir, the Monastery of Zawa Lam Damdin in the Gobi [Зава лам Дамдингийн говь нутгийн Дэлгэрийн чойр хийд]. *Zentralasiatische Studien* 41: pp. 7-42. 2012.
2. Majer Zs., Three Monasteries by the Ongi River [Онгийн гурван хийд]. *Zentralasiatische Studien* 42: pp. 83-134. 2013.
3. Majer, Zs.-Teleki, K., *Monasteries and Temples of Bogdiin khüree, Ikh khüree, or Urga, the Old Capital City of Mongolia in the First Part of the Twentieth Century* [XX зуны эхэн үеийн Их хүрээнийн сүм дуганууд]. 2006 <http://www.mongoliantemples.org/index.php/en/2014-07-01-06-34-46/2014-07-01-06-44-08/old-monasteries>
4. <http://mongoliantemples.org/en/additional-materials/ulaanbaatar-reports-2005-2006/ub-old-monasteries>
5. Majer, Zs.-Teleki, K., *Report on the Interviews Made With Old Monks in 2006 and 2007 in Ulaanbaatar* [Улаанбаатар хотод 2006, 2007 онд ахмад лам нартай хийсэн ярилцлагууд]. 2007 <http://mongoliantemples.org/en/additional-materials/ulaanbaatar-reports-2005-2006/interviews-with-old-monks-06-07>
6. Majer, Zs.-Teleki, K., *Kolostorok régen és ma a mongol vidéken* [Монголын хуучин ба орчин үеийн хөдөөний сүм хийдүүд]. *Kereknyomok. Orientalisztikai és Buddhológiai Folyóirat*, Тан Каруја Buddhista Főiskola, Budapest, 2008/summer (vol. 4.), pp. 74-88.
7. Majer, Zs.-Teleki, K., *On the Current Condition of 190 Old and Present-Day Monastic Sites in the Mongolian Countryside* [Монгол улсын хөдөө орон нутгийн 190 хуучин ба орчин үеийн сүм хийдийн өнөөгийн байдлын тухай]. *Zentralasiatische Studien* 39, 2010, pp. 93–140.
8. Majer, Zs.-Teleki, K., *History of Zaya Gegeenii Khüree, the Monastery of the Khalkha Zaya Pandita* [Халхын Зая бандид гэгээний хүрээний түүх]. Ulaanbaatar 2013.
9. Majer, Zs. – Teleki, K., *Reminiscences of S. Tüdev, Monk of Zayayn Khüree* [Заяын хүрээний лам асан С. Түдэвийн дурдатгал]. In: Charleux, Isabelle (ed.): *Zaya Gegeenii Khüree: History, Architecture and Restoration of a Monastery in Mongolia*. Bulletin du Musée d'Anthropologie Préhistorique de Monaco, 5. Monaco 2016, pp. 99–106.

<sup>111</sup> Майер-Телеки 2023, Телеки.2023.



10. Майер Жужа-Телеки Кристина, *Өндөр настан лам нарын яриа. XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн талаар авсан ярианууд II (2005-2009)*. Улаанбаатар 2023 (хэвлэлд орсон)
11. Teleki, K., Building on Ruins, Memories and Persistence: Revival and Survival of Buddhism in the Countryside, In: *Silk Road 7*, Seattle 2009, pp. 64-73. (also [http://www.silkroadfoundation.org/newsletter/vol7/stjournal\\_v7.pdf](http://www.silkroadfoundation.org/newsletter/vol7/stjournal_v7.pdf))
12. Teleki, K., *Monasteries and Temples of Bogdiin Khüree* [Богдын хүрээний сүм дуганууд] Institute of History. Mongolian Academy of Sciences. Ulaanbaatar 2012.
13. Teleki, K., *Introduction to the Study of Urga's Heritage* [Богдын хүрээний өв соёлын гарын авлага]. Institute of History and Archaeology. Mongolian Academy of Sciences, International Association for Mongol Studies. Ulaanbaatar 2015.
14. Teleki, K., Sain noyon xan kolostorvárosa [Сайн ноён ханы хүрээ]. *Távol-keleti Tanulmányok*, Budapest 2017, 2016/1. pp. 131-162.
15. Teleki, K., *Reminiscences of Old Mongolian Monks*. Interviews about Mongolia's Buddhist Monasteries in the early 20th century [*Өндөр настан лам нарын яриа. XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн талаар авсан ярианууд*] (Budapest Monographs in East Asian Studies 10,) Eötvös Loránd University, Budapest 2022.
16. Телеки Кристина, *Өндөр настан лам нарын яриа. XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн талаар авсан ярианууд II (2007-2017)*. Улаанбаатар 2023 (хэвлэлд орсон)

#### Цахим хуудас

17. [www.mongoliantemples.org](http://www.mongoliantemples.org)
18. [www.amantuuh.socanth.cam.ac.uk](http://www.amantuuh.socanth.cam.ac.uk)

#### Ярилцлагууд

19. Цэгмидийн Лувсан. Гандантэгчэнлин хийд, Улаанбаатар хот, 2006, 2009 он (Майер Жужа, Телеки Кристина)
20. Шижирийн Түгж. Ламрим дацан, Улаанбаатар хот, 2009 он (Майер Жужа, Телеки Кристина)
21. Лочингийн Ишжамц. Гандантэгчэнлин хийд, Улаанбаатар хот, 2006, 2009 он (Майер Жужа, Телеки Кристина)